

Бие даан ажиллах бодлого дасгал

1. 52 модтой хөзрөөс таамгаар нэгийг сугалахад улаан өнгийн эсвэл хүн хөзөр тааралдах магадлалыг ол.

$$\text{Хариу } \frac{8}{13}$$

2. Цүнхэнд 3 хөх, 4 хар бал байв. Цүнхнээс таамгаар 2 бал авахад 1 хар 1 хөх бал байх магадлалыг ол.

$$\text{Хариу } \frac{4}{7}$$

3. Бүгд 5 билет байгаагийн 3 нь хонжвортой түүнээс 4 билет авах туршилт явуулав. хоёр хонжвортой байх үзэгдлийн магадлалыг ол.

$$\text{Хариу } \frac{3}{5}$$

4. 10 суудалтай нэг эгнээ сандалд 5 хүү, 5 охин зэрэгцэн суусан бол бүх хөвгүүд зэрэгцэн суух магадлалыг ол.

$$\text{Хариу } \frac{1}{42}$$

5. Утасны дугаар гурван оронтой бөгөөд 4,5,6 гэсэн цифрүүдээс (цифр давтагдаж болно) тогтоно. Утасны дугаар 645 байх магадлалыг ол.

$$\text{Хариу } \frac{1}{27}$$

6. Хонжворт сугалааны 100 билетний 3 нь хонжвортой 2 билет авав. Хоёулаа хонжвортой байх магадлалыг ол.

$$\text{Хариу } \frac{1}{1650}$$

7. Бүтээгдэхүүнийг 3 дамжлагаар хийдэг. Дамжлага бүрийн найдвартай ажиллах магадлал харгалзан 0,9,0.8,0.7 бол бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэх магадлалыг ол.

$$\text{Хариу } 0,504$$

8. Дэлгүүрт орсон хүн худалдаа хийх магадлал 0.4 бол дэлгүүрт орсон 5 хүнээс 3 хүн худалдаа хийх магадлалыг ол.

$$\text{Хариу } \frac{144}{625}$$

9. “Сургууль” гэдэг үгийн үсгүүдээр бүтээсэн 8 үсэгтэй үгийн 3 дахь үсэг “с” үсэг байх магадлалыг ол.

$$\text{Хариу } \frac{1}{8}$$

10. Хоёр оюутан номын санд 14-15 цагийн хооронд уулзахаар тохиролцжээ. Түрүүлж ирсэн нь 20 минут хүлээгээд явна. Тэдгээр оюутны уулзах магадлалыг ол.

$$\text{Хариу } \frac{5}{9}$$